

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэгдүгээр бүлэг.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Төрийн аудитын тухай хуулийн дагуу УИХурлын Төсвийн байнгын хорооноос баталсан аудит хийх сэдэв, ҮАГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон гүйцэтгэл, нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллав.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2018 оныг “Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” жил болгосонтой холбогдуулан тус газраас ажилтнуудад ажлын чанарыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагыг тавьж, тайлант хугацаанд МУЕАудиторын тушаалаар шинэчлэн баталсан бүтэц, 12 орон тоотойгоор ажиллаж байгаа ба багийн зохион байгуулалтыг шинэчлэн санхүүгийн аудитын албаны 3, гүйцэтгэлийн аудитын албаны 3, нийцлийн аудитын албаны 3 аудитор байхаар тус тус зохион байгуулж, нийт 3005 хүн өдөр ажилласан байна.

Удирдлагын зөвлөлийн хурлыг 6 удаа хийж тухай бүр асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.

Тэргүүлэх аудитор ажилтнуудтай 2018 оны үр дүнгийн гэрээ байгуулж, баталгаажуулсан ба хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээг дүгнэсний зэрэгцээ хагас бүтэн жилийн тайлан, статистик мэдээг журмын дагуу хугацаанд нь гаргаж ҮАГ-т хүргүүлж ирлээ.

Урд оны болон 2018 оны аудитаар тавигдсан акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллав.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн 4 сэдвээр, нийцлийн 2 сэдвээр, орон нутгийн ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилгаар 4 сэдвээр, санхүүгийн тайлангийн аудитаар 278, бүгд 288 тайланд аудит хийсэн байна.

Тайлант хугацаанд 322 төрлийн 8691.0 сая төгрөгийн зөрчил илүүлснээс 95 төрлийн 1331.0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан.

Мөн 206 төрлийн зөвлөмж өгснөөс 149 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 72.3 хувь, 101 төрлийн 6496.4 сая төгрөгийн албан шаардлага өгч 69 төрлийн 2398.5 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлэн хэрэгжилт 36.9 хувь, 20 төрлийн 26.0 сая төгрөгийн төлбөрийн актаас 19 төрлийн 18.4 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 70.8 хувьтай гарсан байна. Аудитаар тавигдсан төлбөрийн актаас 18.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Аудитаар байгууллага, аж ахуйн нэгжид үр өгөөж тооцсоноор 4546.2 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн тухайн байгууллагуудын удирдлагаар хүлээн зөвшөөрүүлэн, төсвөөс авсан санхүүжилтийн 1 төгрөгийн хариуд 18 төгрөг 57 мөнгөний үр өгөөж бий болгосон байна.

Хоёрдугаар бүлэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2.1 Санхүүгийн тайлангийн аудитаар:

МУЕА-ын 2017 оны 07 дугаар сарын 16-ны А/134 тоот тушаалаар 279 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх байгууллагын жагсаалт батлагдсан ба оны эцэст Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэг нэмэгдэж, нийтдээ 280 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийхээс 59 төсвийн шууд захирагчид итгэл үзүүлэх, 88 байгууллагыг түүвэрт хамруулах, 133 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргахаар батлагдсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар ОННТайлан-1, 19 сумын ТТЗ-ын нэгтгэсэн тайлан,



43 тусгай сан, 192 төсвийн шууд захирагч, 23 аж ахуй нэгж, нийтдээ 278 байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хамруулснаас 59 төсвийн шууд захирагчид итгэл үзүүлж, 88 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 131 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан байна. Аудит хийгдээгүй 2 байгууллага болох ӨВ АЗЗА компани, Хархорин АЗЗА компанийн ТУЗ-өөс аудит хийлгэх байгууллагаа өөрсдөө

сонгосон тул аудит хийгдээгүй болно.


Бие даасан дүгнэлт гаргуулах 131 байгууллагаас 108 байгууллагад аймаг дахь ТАГ, орон нутгийн өмчит 23 байгууллага аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс гэрээний үндсэн дээр Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК аудитыг гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар 118 байгууллагад зөрчилгүй, 13 байгууллагад хязгаарлалттай дүгнэлтийг өгч, сөрөг болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт гараагүй байна.



Аудитаар нийт 259 төрлийн 2458.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 95 төрлийн 1331.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 18 төрлийн 16.2 сая төгрөгийн акт тавьснаас 18 төрлийн 15.8 сая төгрөгийн актыг барагдуулан биелэлт 97.5 хувь, 47 төрлийн 277.4 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 46 төрлийн 242,3 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлт 87.3 хувь, 139 төрлийн зөвлөмж өгсний 126 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 90.6 хувьтай тус тус гарлаа.

Үүнээс гэрээгээр гүйцэтгэсэн хувийн аудитын компаниуд орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 0.8 сая төгрөгийн албан шаардлага, 22



төрлийн зөвлөмж хүргүүлж, 2.7 сая төгрөгийн үр өгөөжийг тооцон хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд акт, албан шаардлагыг бүрэн барагдуулж, зөвлөмж 13-ыг хэрэгжүүлсэн дүнтэй байна.

Нийт илрүүлсэн 259 зөрчлөөс нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 140, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 22, дотоод хяналт хариуцлагатай холбоотой 34, орлого бүрдүүлэлттэй холбоотой 18, арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулахтай холбоотой 41 зөрчил илэрчээ.

Өгсөн зөвлөмжийн 13 нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 60 нь бүртгэл тайлагналтай холбогдолтой, 25 нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй, 41 нь дотоод хяналт сайжруулах зөвлөмжүүд өгөгдсөн байна.

Тайлант онд актын 0.8 сая төгрөг, албан шаардлагын 35.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2431 хүн өдөр ажиллаж, 16.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлжээ.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгдсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгсөн бөгөөд тайланд дараах залруулгыг хийсэн байна. Үүнд:

- Аймгийн төрийн сангийн арилжааны банкин дахь нэмэлт санхүүжилтийн 2017 оны эцсийн үлдэгдэл 15.5 сая төгрөгийг кассын үлдэгдлээр тайлагнасныг залруулсан.
- Гэр бүл хүний хөгжлийн төвийн санхүүгийн тайланд "Дөлгөөн хайрхан-Уул аудит" компани аудит хийж 19.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө орлого авхуулж залруулга хийгдсэн боловч тайланг дутуу нэгтгүүлснийг залруулан бүртгэсэн.
- Бат-Өлзий сумын Соёлын төвийн барилгын санхүүжилтэд орон нутгийн төсвөөс 2017 онд 579.9 сая төгрөгийг олгосон боловч гэрээний үнийн дүнгийн 949.9 сая төгрөгөөр орлого авч 369.9 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залруулсан болно.

Хязгаарлалттай дүгнэлт өгсөн Бүрд, Богд сумын ЭМТөв, Зүүнбаян-Улаан, Хархорин, Уянга сумдын ИТХ, Хужирт сумын ЗДТГ, Тарагт сумын Туяа багийн бага сургууль, Өлзийт, Хайрхандулаан, Хужирт сумын Соёлын төв, Гучин-Ус, Хужирт сумдын Төрийн сан, аймгийн Онцгой байдлын газар зэрэг 13 байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 30-ны А/337 тоот захирамжаар нэр дурдсан байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт албан тушаалын цалинг 1 сарын хугацаатай 20 хувиар бууруулах хариуцлага тооцож, ОБЕГ-ын даргын тушаалаар аймгийн ОБГ-ын даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, нягтлан бодогчийг албан тушаал бууруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хамтран ажиллах хараат бус аудитын компанийг МУ-ын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 тушаалаар батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулах үйл ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу явуулж хураангуй жагсаалтад бүртгэсэн Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК-ийн Өвөрхангай аймгийн салбарыг сонгон шалгаруулсан.

Аудитын компаниудын гэрээт ажлын хөлсөнд 25.2 сая төгрөгийн аудитын төлбөрийн гэрээ хийж байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан гүйцэтгэлийг хянан санхүүжүүлсэн.

Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлалын дагуу Дөлгөөнхайрхан-Уул аудит ХХК, Б энд С аудит ХХК компаниудын хийсэн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийж баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгж, сангуудын үе шатны ажлуудыг СТАУС программд 100.0 хувь оруулсан.

Санхүүгийн тайлангийн 18 аудитын төлөвлөлтийн шатны буюу явцын аудитууд хийгдэж байна.

Санхүүгийн 2018 оны тайланд аудит хийх хуваарийг аудитор бүрээр гаргаж, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулав.

Гуравдугаар бүлэг.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Гүйцэтгэлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 4 сэдвийн, аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалгаар тайлант хугацаанд 2 сэдвийн, өөрийн санаачлагаар 1 сэдвийн хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 63 байгууллага, сумдыг хамруулан 8 төрлийн 6.9 сая төгрөгийн акт тавьснаас 1 төрлийн 2.6 сая төгрөгийн актыг барагдуулан биелэлт 37.7 хувь, 8 төрлийн 1353.9 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 7 төрлийн 1255.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлт 92.8 хувь, 29 төрлийн зөвлөмж өгсний 9 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 31.0 хувьтай гарсан байна.

Тус аудитаар 1163.5 хүн өдөр ажиллаж, 1404.2 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн.

3.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аудит хийсэн аудитаар Худалдан авах ажиллагааг хууль, журмын

дагуу зохион байгуулаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгосон байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 70 хүн өдөр ажилласан.

Өвөрхангай аймагт 2017 онд эрх шилжин улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн 2 бараа, 15 их засварын ажил байгаа бөгөөд НТШ-аар 1, харьцуулалтын аргаар 14 ажил үйлчилгээг сонгож, тендерийн зар, урилгыг цахим сайт болон үндэсний хэмжээний өдөр тутмын сонин хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж, нийт худалдан авалтын 58.8 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар БОЭТ-ийн хэсэгчилсэн засварын 80.0 сая төгрөгийн засварын ажил болон сантехникийн засварын 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, аймгийн ХХҮГ-ын байрны цахилгааны засварын 50.0 сая төгрөгийн засварын ажил, Занабазарын музейн барилгын дээврийн засварын ажил, Төгрөг сумын Мазарын голын услалтын системийн боомтын 130.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажил, Бат-Өлзий сумын ЕБСургуулийн гэрэл цахилгааны засварын ажлуудын худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдаагүй, ажлын чанар, хэрэгжилт хангалтгүй, гэрээт ажлыг дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон зөрчлүүд илэрсэнд 2.6 сая төгрөгийн акт тогтоож, 214.4 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 297.0 сая төгрөгийн үр өгөөж тооцоноос тавьсан акт, албан шаардлагыг бүрэн барагдуулсан.

Аудитаар тендерийг хууль журмын дагуу зохион байгуулж, тендерт оролцогчдын чадварыг үнэн зөв үнэлж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байх, гүйцэтгээгүй ажилд санхүүжилт илүү олгохгүй байх, төсөвт тусгагдсан ажлыг дутуу буюу чанаргүй хийсэн гүйцэтгэгч компаниудаар ажлыг гүйцээж хийлгэх, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарт хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож холбогдох арга хэмжээ авч байх зөвлөмжүүдийг өгсөн.

3.2 Аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар: “Өвөрхангай аймгийн төсвийг үндэслэлтэй төлөвлөж, орлого нийт дүнгээр давж, төлөвлөсөн зардлыг хэмнэсэн байна” гэсэн дүгнэлт өгч зориулалт бусаар зарцуулсан 85.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, үр өгөөж тооцсон бөгөөд 85.5 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоосон. Аудитаар нийт 2 хүн 10 өдөр ажиллаж 1.5 сая төгрөгийн аудитын зардал гарсан байна.

3.3 “Өвөрхангай аймгийн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн”-д /САГ-2018-03-СА/ аудитыг хийж, “Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан хэдий ч, үйл ажиллагаа төдийлөн үр нөлөөтэй хэрэгжээгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгөв.

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Төгрөг, Уянга, Богд, Баруунбаян-улаан, Баянгол сумдын төрийн сан, аймгийн төрийн санд харьяалагддаг байгууллагуудыг хамруулан 2018 оны 09 дүгээр сарын 09-өөс 11 дугаар сарын 04-ний өдрүүдэд гүйцэтгэв. /80 хүн өдөр ажилласан/

Төрийн сангийн төлбөр тооцоог хууль журмын дагуу аюулгүй, түргэн шуурхай гүйцэтгэж байгаа ч хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдээгүй, алдаатай хасах залруулгын гүйлгээ, орлого бууруулах гүйлгээ дэмжих баримт дутуу, амлалтын бүртгэл хөтлөөгүй байгаа нь үнэн зөв байдал бүрэн хангагдаагүй байжээ.

Аудитаар 11 төрийн сангийн 110 байгууллагын 207 дансны 500.0 мянган төгрөгөөс дээших 19558 гүйлгээг анхан шатны баримтаас түүвэрлэн үзэхэд шаардлага хангахгүй 204 гүйлгээ гарчээ.

Дээрх шаардлага хангахгүй 204 гүйлгээнээс 102 гүйлгээ хүчин төгөлдөр болон иж бүрэн мэдээлэлтэй төлбөрийн хүсэлтээр гүйлгээ хийгдээгүй, 4 гүйлгээ төлбөрийн болон анхан шатны дэмжих баримт нь төрийн сангийн тэмдэглэгээтэй тохирохгүй байгаа, 41 орлого бууруулах гүйлгээ дэмжих баримт дутуу хийгдсэн, 55 гүйлгээ залруулсан боловч төлбөрийн хүсэлт хавсаргаагүй, 2 гүйлгээ төлбөрийн хүсэлт бичигдсэн өдрөөс хойш ажлын 4-7 хоногийн дараа хийгдсэн байна.

Аудитаар аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, сумдын Санхүүгийн Албаны дарга нарт: Төсвийн байгууллагын бүртгэлийн данснаас гүйлгээ хийхдээ байгууллагын баталгаат гарын үсэг, байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан төлбөрийн хүсэлтийг хянаж байх, төлбөрийн хүсэлтийг үндэслэх анхан шатны болон дэмжих баримыг төрийн сангийн тэмдэглэгээтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах, ажлын 3 хоногт багтаан гүйлгээ хийх, орлого бууруулсан залруулга хийхдээ орлогын хуулгыг үндэслэн гүйлгээ хийж, ажлын баримтад хавсаргах, амлалтын бүртгэлийг хөтөлж хяналт тавьж байх, нэмэлт санхүүжилтийн эрхийг дэмжих баримтыг үндэслэн хянан олгох, нэмэлт санхүүжилтийн материалыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, сумдын төрийн сангуудад төсвийн хэрэгжилт, мөнгөн хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналтыг төлөвлөгөөний дагуу бүрэн хэрэгжүүлж ажиллах, буруу шивсэн, баталгаажуулж зарлагын гүйлгээг залруулахдаа төлбөрийн хүсэлтийг хавсаргаж байх гэсэн 10 зөвлөмжийг өгсөн ба тайланг тушаалаар баталгаажуулан хувийг ЯАГ-ын Санхүүгийн аудитын газар, аймгийн ИТХурал, аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэст тус тус хүргүүлэв.

3.4 2018 оны “Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц” /САГ-2018/02-СА-д хийсэн аудитаар Өвөрхангай аймгийн хэмжээнд 2018 оны төсвийн төлөвлөлт түүний хэрэгжилт хангалттай, ТЕЗ-дын хэрэгжүүлж буй хөтөлбөр нь хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байна гэсэн дүгнэлтийг өгөв.

Аудитыг 2018 оны 09 дүгээр сарын 17-ноос 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд хийж гүйцэтгэв. /70 хүн өдөр ажилласан/

Аймгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогыг 8264.1 сая төгрөгөөр төлөвлөж эхний 9 сарын гүйцэтгэлээр 8204.2 сая төгрөг оруулж орлогын төлөвлөгөөний биелэлт 99.2 хувийн биелэлттэй.

Сумын төсөвт орох татварын орлогоор 3199.5 сая төгрөг оруулахаас эхний 9 сарын гүйцэтгэлээр 2928.4 сая төгрөг оруулж 91.5 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн төсөвт орсон нийт татварын орлогын 73.6 хувийг аймгийн төсөвт, 26.4 хувийг сумын төсөвт оруулсан байна.



Өмнөх хоёр оны орлогын гүйцэтгэл жилээс жилд өсөлттэй байхад 2018 оны төлөвлөгөөг 2017 оны гүйцэтгэлээс 957.6 сая төгрөгөөр бууруулж баталсан нь аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөсөн байх магадлалтай гэж үзсэн байна.

Сумын татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлтэй

харьцуулж үзэхэд нийт дүнгээр 1390,7 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн ч торгуулийн орлого 82.5 сая төгрөг, ус ашигласны төлбөр 2.8 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 10.3 сая төгрөг, ойн нөөцийн төлбөр 454.3 сая төгрөгөөр тус тус буурч батлагджээ.

2018 оны аймгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 78857.9 сая төгрөгөөр батлагдаж, эхний 9 сарын гүйцэтгэлээр 58353.8 сая төгрөг буюу 74.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө жилээр	Төлөвлөгөө 9.30	Гүйцэтгэл 9.30	Гүйцэтгэлийн явц %	9 сарын 30-ны гүйцэтгэл %
Тусгай зориулалттай шилжүүлгээс санхүүжих	45706.5	33115.2	33065.2	72.3%	99.8%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	25586.5	19008.9	20020.4	78.2%	105.3%
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	4374.2	3329.2	3180.0	72.6%	95.5%
Төсөвт байгууллагын үйл ажиллагаа, СХСангийн зээлийн эх үүсвэр, урьд оны үлдэгдлээс	3190.7	2900.5	2593.6	81.2%	89.4%
Дүн	78857.9	58353.8	58859.2	74.6%	100.8%

Аймагт төвлөрүүлэх орлого 9 дүгээр сарын 30-ны байдлаар 76.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөрийн орлогын гүйцэтгэл харьцангуй бага байна.

Сумын орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 91.5 хувийн биелэлттэй байна. Үйл ажиллагааны орлого, бууны албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, нохойны татвар зэрэг орлогууд 70-аас доош хувийн гүйцэтгэлтэй байгаад анхаарч үзэх шаардлагатай байна.

НД-ын сангийн орлогын гүйцэтгэл 73.5 хувьтай, зарлагын гүйцэтгэл 69.0 хувьтай байна.

Төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад 9.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх боломж байжээ.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 2018 онд 78857.9 сая төгрөгөөр баталж, 9 сарын 30-ны гүйцэтгэлээр 52255.3 сая төгрөг зарцуулан 66.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Зарлагын гүйцэтгэлийг 9 сарын төлөвлөгөөтэй харьцуулахад 6833.8 сая төгрөгийн хэмнэлттэй буюу 88.4 хувийн гүйцэтгэлтэй байв.

/сая төгрөгөөр/

	Төсвийн зарлага	2018 оны төлөвлөлт	9.30-ны төлөвлөлт	9.30-ны гүйцэтгэл	Зөрүү	Гүйц-л жил	Гүйц-л 9.30
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34538.6	25540.3	24659.1	-881.2	71.4 %	96.5%
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4177.3	3095.2	3002.8	-92.4	71.8 %	97.0%
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6689.8	4222.7	3898.8	-323.9	58.3 %	92.3%
4	Хангамж, бараа материалын зардал	1214.5	925.3	823.9	-101.4	67.8 %	89.0%
5	Нормативт зардал	3284.7	2188.0	1785.4	-402.6	54.3 %	81.5%
6	Эд хогшил, урсгал засварын зардал	505.1	467.6	409.8	-57.8	81.1 %	87.6%

7	Томилолт, зочны зардал	209.3	160.2	125.7	-34.5	60.0 %	78.4%
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1475.8	1250.2	1041.3	-208.9	70.5 %	83.2%
9	Бараа үйлчилгээний бусад зардал	2299.8	1829.2	1663.1	-166.1	72.3 %	90.9%
10	Татаас	260.7	189.1	158.6	-30.5	60.8 %	83.8%
11	Урсгал шилжүүлэг	13872.6	10128.5	8389.5	-1739	60.4 %	82.8%
12	Хөрөнгийн зардал	7196.4	6177.0	5020.0	-1157	69.7 %	81.2%
13	Эргэн төлөгдөх зээл	3133.3	2915.8	1277.3	-1638.5	40.7 %	43.8%
	Нийт зардлын дүн	78857.9	59089.1	52255.3	-6833.8	66.2 %	88.4%

2018 оны Төсвийн тухай хуулиар Өвөрхангай аймагт улсын төсвийн хөрөнгөөр 59 төсөл арга хэмжээ болон барилга байгууламжид 31771.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 29982.0 сая төгрөгийн эрхийг шилжүүлсэн байна. 2018 оны 9 дүгээр сарын байдлаар хөрөнгө оруулалтын 55 арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 30, харьцуулалтын аргаар 7 тендер зарласан бөгөөд 5 тендер дахин зарлагдаж шууд гэрээ байгуулан нийт 57 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тендерийн зар, урилгыг цахим сайтаар зарлан мэдээлж, нийт худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын явц 90-100 хувийн гүйцэтгэлтэй 30, 60-85 хувийн гүйцэтгэлтэй 10, 55-30 хувийн гүйцэтгэлтэй 6, 10-40 хувийн гүйцэтгэлтэй 5, ажил нь эхлээгүй гэрээ байгуулах шатанд 4 төсөл арга хэмжээ байна.

Барилга байгууламж угсралтын 8 ажлын санхүүжилт он дамжиж төсөвлөгдсөн тул энэ онд ашиглалтад орохооргүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 4188.0 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8, харьцуулалтын аргаар 3 тендер зарлаж, 7 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх эрхийг суманд болон байгууллагад шилжүүлж, 1 тендер дахин зарлагдаж шууд гэрээ байгуулан нийт 12 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тендерийн зар, урилгыг цахим сайтаар зарлан мэдээлж, нийт худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулжээ.

Харин 2 ажлын худалдан авах ажиллагааг зарлаагүй байна. Төлөвлөгдсөн 30 төсөл арга хэмжээнээс 9 төсөл арга хэмжээ нь зураг төсвийн зардал болон үйл ажиллагааны зардал байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын явц 95-100 хувийн гүйцэтгэлтэй 15, 76-95 хувийн гүйцэтгэлтэй 1, 60-75 хувийн гүйцэтгэлтэй 10, ажил нь эхлээгүй 3 төсөл арга хэмжээ байна.

Хөрөнгө оруулалтын барилга угсралт болон засварын ажлууд дээр аймгийн ГХБХБГазар, Барилгын хөгжлийн төв, Зураг төсвийн зохиогчоос газар дээр нь зохих хяналтуудыг тавьж заавар зөвлөгөө өгч ажлын дэвтэрт баримтжуулж ажилласан байна.

ТЕЗ-дын хэрэгжүүлж буй хөтөлбөр нь хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцэж, төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн СТСХэлтсийн даргад хандаж: Аймагт төвлөрүүлэх татварын орлогыг татварын бааз суурь нэмэгдэж байгаатай уялдуулан нөөц бололцоог бүрэн судалж бодитоор төлөвлөх, буу эзэмшигчдийн бүртгэл судалгааг холбогдох байгууллагуудтай хамтарч үнэн зөвөөр бүртгэж, бууны албан татварын үндэслэлийг сайжруулах гэсэн 2 зөвлөмж өгөгдсөн. Аудитын тайланг тушаалаар

баталгаажуулан хувийг ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар, аймгийн ИТХурал, аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.5 Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах талаар:

Тус газраас 2019 оны орон нутгийн төсвийн орлогыг 2 төрлийн 209.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, зардлыг 6 төрлийн 2029.1 сая төгрөгөөр бууруулах саналыг аймгийн ИТХурал, ЗДТГ-т хүргүүлснээс төсвийн орлогыг 1 төрлийн 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг хүлээн авсан байна.

Дөрөвдүгээр бүлэг.

НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудитаар ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 сэдвийн, аймгийн ИТХ-ын хүсэлт, захиалга болон өөрийн санаачилгаар 2 сэдвийн хүрээнд аудит хийж, давхардсан тоогоор 276 байгууллага, сумдыг хамруулан 1 төрлийн 7.2 сая төгрөгийн акт тавьснаас актын хэрэгжих хугацаа болоогүй, 46 төрлийн 4865.1 сая төгрөгийн албан шаардлага өгснөөс 16 төрлийн 900.3 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлт 18.5 хувь, 38 төрлийн зөвлөмж өгсний 14 зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлт 36.8 хувьтай гарсан байна.

Тус аудитаар 781 хүн өдөр ажиллаж, 3125.8 сая төгрөгийн үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн.

4.1 Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулиар МАН-аас 38 суудал авсан төлөөлөгчдийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж ҮАГ-т хүргүүлсэн.

4.2 Өвөрхангай аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, “Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд хуулийг 95.5 хувьтай хэрэгжүүлж, хуулийн 6.9, 8.1 дэх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгөв.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 24-өөс 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. /75 хүн өдөр ажилласан/

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд мэдээлсэн байдал

Хуулийн хугацаа /жил бүр/	I/10			VIII/10	IV/25	IX/15
Шилэн дансны хуулийн заалт	6.1.1 Тухайн жилийн төсөв	6.1.1. ОНХС-ийн төлөвлөгөө	6.1.1. ХАА-ны төлөвлөгөө	6.1.2. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	6.1.2.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	6.1.3. Дараа жилийн төсвийн төсөл
3.1.1, хамаарах байгууллагууд	3.1.2-д 244	244	244	244	244	244

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



Мэдээлсэн байдал	Тийм	207	19	100	229	230	191
	Үгүй	2	0	2	4	10	17
	Хугацаа хоцорсон	16	1	9	8	1	10
	Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй	19	224	133	3	3	26
	Тухайн мэдээллийг мэдээлсэн хувь	92.0	95.0	90.1	95.0	95.4	87.6

Хүснэгт 2-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд мэдээлсэн байдал үргэлжлэл

Хуулийн хугацаа /жил бүр/	VIII/15	IV/25	VII/01	Улирал бүр		
Шилэн дансны хуулийн заалт	6.1.4. Санхүүгийн тайлан /хагас жил/	6.1.4. Санхүүгийн тайлан /жилийн эцсийн/	6.1.5. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	6.1.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	6.1.6. Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	
3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд	244	244	244	244	244	
Мэдээлсэн байдал	Тийм	208	214	175	153	188
	Үгүй	11	15	21	27	21
	Хугацаа хоцорсон	18	8	8	13	0
	Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй	7	7	40	51	35
	Тухайн мэдээллийг мэдээлсэн хувь	87.8	90.3	85.8	79.3	90.0

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5-д заасныг дараах хүснэгтээр харуулав.

6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	693
	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний мөнгөн дүн (сая. төг)	21545.0

худалдан авалтын мэдээлэл	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	1
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	51.8
6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	1547
	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний мөнгөн дүн (сая. төг)	30445.8
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	55
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	654.67
6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	3065
	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний мөнгөн дүн (сая. төг)	82058.6
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	146
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	2673.8

Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан 42 аж ахуй нэгж 12228.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 4 байгууллага байгаагаас 3 байгууллага шилэн дансны цахим хуудаст бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна.

Аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт: Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдтэй арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээнд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг тусгаж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэх гэсэн 4 зөвлөмжийг өгөв.

4.3 . Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд нийцлийн аудитыг гүйцэтгэж, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу хуваарилан зарцуулж, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл эзэлж, сангуудад тавих хяналт хангалтгүй байна” гэсэн дүгнэлтийг өгөв.


Аудитыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулж, 2018 оны 09 дүгээр сарын 14-ээс 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. /70 хүн өдөр ажилласан/

Аудитаар холбогдох хүмүүст 9 зөвлөмжийг өгч, 26 төрлийн 3964.8 сая төгрөгийн албан шаардлага өгсөн

ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд дараах зориулалт бусаар зарцуулсан зөрчил гарсан байна. Тухайлбал:

- Бүрд суманд Цагдаагийн мотоцикл авахад 2.0 сая төгрөг
- Төгрөг суманд Ахмадын жилийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах зардалд 0.5 сая төгрөгийг медалийн үнэд шилжүүлсэн.
- Нарийнтээл сумын Бизнес хөгжлийн төвийн барилгын цонх солих ажил Бат угсралт констракшин ХХК-тай гэрээг байгуулж, 10.1 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээ байгуулахаас өмнө олгож Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6, Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.13.7 -д заасан заалтуудыг зөрчжээ.

Богд сумын Засаг даргын 2017 оны а/15 дугаар захирамжаар ажлын хэсгийг томилж, Хуурай сүүний үйлдвэрийн барилгын ажлыг ашиглалтад оруулах комиссын гишүүний саналаар 95 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авсан байна. Барилгын ажлыг аудитаар газар дээр очиж үзэхэд шал цутгаагүй, тусгаарлах хана



Зураг 1: ТЭЗҮ-гүй чанаргүй гүйцэтгэсэн байна.



Зураг 2: Бүртгэлд тусгаагүй барилга.

чийгтэй, эмульс халтартсан чанар байдлын хувьд хангалтгүй байжээ.

Арвайхээр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга 851.5 сая төгрөгийн санхүүжилтээр баригдаж, ашиглалтад оруулсан боловч тайлан бүртгэлд тусгаагүй байв.

Сум хөгжүүлэх сангийн нийт олгосон зээлийн 38.5 хувь нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл байхад хяналт хангалтгүй, хариуцлага тооцоогүй байна.

Аудитаар аймаг, сумдын Засаг дарга нарт: ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах, ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүн, зарцуулалтад ЗДТГ-ын ХБТХэлтэс хяналт тавьж, жилийн эцэст тайлан гаргаж байх, сумууд СХС-ийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, төлөвлөлт, бүрдүүлэлтийг хууль, журмын дагуу хугацаанд нь төвлөрүүлэх, Зөвлөлийн гишүүд төсөл сонгон шалгаруулахдаа үйл ажиллагаа явуулах ажлын байрыг судалж олгох, СХС-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөр ирүүлсэн төсөл бүрийг журамд заасан шалгуураар нэг бүрчлэн хэлэлцэн шийдвэрлэх, сумдын СХС-ийн зээл хариуцсан мэргэжилтнүүдийн ажил дүгнэх үзүүлэлтэд СХС-ийн эргэн төлөлтийн талаар оруулж, ажлын хариуцлагыг сайжруулах, Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн

НИЙТ ХУГАЦАА ХЭТЭРСЭН, ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ (САЯ ТӨГРӨГӨӨР)



зээлдэгчид хууль, журмын дагуу алданги тооцож байх, журмын шаардлага хангасан үнэлгээтэй барьцаа хөрөнгийн гэрээг байгуулах, 2011 оноос олгосон зээл тус бүрээр мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлж программд оруулах гэсэн 9 зөвлөмжийг өгч, тайланг тушаалаар баталгаажуулан хувийг ҮАГ-ын Нийцлийн аудитын газар, аймгийн ИТХурал, аймгийн Засаг дарга, аймгийн ХХААГ газар болон холбоогдох сумдын удирдлагад хүргүүлэв.

Тавдугаар бүлэг.

ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН САНААЧЛАГААР:

5.1 Өвөрхангай аймагт Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар: Хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна гэсэн ерөнхий дүгнэлтийг өгсөн ба 60 хүн өдөр ажилласан.

Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 2017 онд хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 2048.5 сая төгрөг батлагдаж, 1971.0 сая төгрөгийг зарцуулжээ. Үүний 80.3 хувь нь хөрөнгө оруулалтад, 19.7 хувь нь арга хэмжээнд зарцуулагдсан байна.

Аудитаар 1054.0 сая төгрөгийн 3 албан шаардлага тавигдаж, 1100.0 сая төгрөгийн үр өгөөж тооцсон ба албан шаардлагын 956.0 сая төгрөгийг барагдуулж, биелэлт 90.7 хувьтай гарчээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар Бат-Өлзий сумын Соёлын төвийн барилга угсралтын 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй ДШЛ ХХК-ийг шалгаруулсан, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад зөөлөн эдлэл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох тус бүр 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулаагүй, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй аж ахуйн нэгжүүдийг шалгаруулсан зөрчлүүд илэрсэн байна.

Гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс чанаргүй бараа нийлүүлсэн байна. Үүнд: Гэр нийлүүлэх тендерээр олгосон өрхүүдээр орж, гэрийн чанар байдалтай танилцахад гэрийн унь, хана цуулбар биш зүсмэл байгаа учраас хугарсан, тооно, багана заадлаараа салсан, хаалганы углуурга ангархай чанар муутай байжээ.



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад нийлүүлсэн хөнжил гудас нь БНХАУ-д үйлдвэрлэсэн, овор хэмжээ ихтэй хөвсгөр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, чийг их татдаг, хүүхдүүдийн биеийг хөлөргөдөг, цагаан хэрэглэл нь угаах бүрд будаг гарч байгаа тул ихэнх цэцэрлэг хэрэглээгүй байна.

Хөнжил, гудасны материал синтепон гардаг

Цагаан хэрэглэл будаг



Аудитаар тендерийг хууль журмын дагуу зохион байгуулж, тендерт оролцогчдын чадварыг үнэн зөв үнэлж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулж байх, захиалагч байгууллагад техник хяналтын зардлыг гэрээний дагуу бүрэн санхүүжүүлж, барилга угсралт, их засварын ажлын явц, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарт хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцож холбогдох арга хэмжээ авч байх, Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг хууль, журам, стандартын дагуу боловсруулж байх, Хөрөнгө оруулалтын ТАХ-г хүлээн авахдаа тендерт шалгарсан болон гэрээнд заасан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо хэмжээтэй тулган үзэж, зөрүүтэй тохиолдолд гүйцэтгэгчид буцааж шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээг авч байх зөвлөмжийг өгсөн.

5.2 Өвөрхангай аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын 2017 оны үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитаар “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх нь тодорхойгүй хүнсийг хүүхдүүдэд олгосоор байна” гэсэн дүгнэлтийг өгсөн ба 126 хүн өдөр ажилласан.

Өвөрхангай аймгийн Ерөнхий боловсролын 29 сургууль “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 2017 онд 1028.2 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 1017.4 сая төгрөгийн төсөв зарцуулж, 10.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитыг Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 1, 2, 4 дүгээр сургууль, Мэргэд сургууль, Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор, Уянга сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Хархорин сумын Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, ГСБСургууль, Хужирт, Бат-Өлзий, Төгрөг, Богд, Гучин-Ус, Есөнзүйл, Баян-Өндөр сумдын ЕБСургуулиудын 773.2 сая төгрөгийн санхүүжилтийг хамруулсан нь үдийн цай хөтөлбөрийн төсвийн 76.0 хувьд аудит хийгдсэн байна.

Аудитаар 15 төрлийн 648.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч үр өгөөж тооцсон ба 648.3 сая төгрөгийн албан шаардлагыг барагдуулж, биелэлт 100.0 хувьтай гарсан.

Үдийн цай хөтөлбөрийн төсвийг оновчтой төлөвлөж, зарцуулсан ч, тендерийг хууль журмын дагуу сонгон шалгаруулаагүй, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг үнэн зөв тайлагнаагүй, үдийн цай хөтөлбөрийн орчны эрүүл ахуй халдваргүйжүүлэлтийн шаардлага бүрэн хангагдаагүй, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх нь тодорхойгүй хүнсний

бүтээгдэхүүн олгосон, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн байгууллагууд хяналт хийдэггүй, насны бүлгээр илчлэгийг тооцоогүй, хориглосон хүнсний бүтээгдэхүүн олгосоор байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

Үдийн цайны хэрэгжилт, эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэхэд журмын дагуу байнга хяналт тавих, хөтөлбөрийн гүйцэтгэлийг сайжруулан тодорхой ажлыг зохион байгуулж ажиллах, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг үнэн зөв тайлагнах, үдийн цайны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хууль, журмын дагуу зохион байгуулах, хоол, хүнсийг Мэргэжлийн хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд улирал бүр хамруулах, бага ангийн багш нарыг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах, эрүүл ахуй халдваргүйжүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, хориглосон хүнсийг олгохгүй байх, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгжүүдийн гэрээг улирал бүр дүгнэж зөрчилтэй бол гэрээг цуцлах арга хэмжээ авах, сурагчдын ирцийн бүртгэлийг үнэн зөв хөтлүүлэх, санхүүжилтийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээр тооцон олгох гэсэн зөвлөмжүүдийг өгчээ.

5.3 “Газрын төлбөрийн хуулийн хэрэгжилт, орлого бүрдүүлэлт, үр дүн”-д нийцлийн аудитыг гүйцэтгэж, “Газрын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, төлбөрийг дутуу төлөвлөж, тайланг зөрүүтэй мэдээлсэн байна” гэсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитыг аймгийн ГХБХБГазар, Бат-Өлзий, Уянга, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Арвайхээр сумдыг хамруулж, 2018 оны 05 дугаар сарын 21-ээс 09 дүгээр сарын 7-ны өдрүүдэд гүйцэтгэв. /120 хүн өдөр ажилласан/

Аудитаар 251.9 сая төгрөгийн албан шаардлага, 7.2 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, 259.2 сая төгрөгийн үр өгөөж тооцсон ба албан шаардлагыг бүрэн барагдуулж, 7.2 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй гарав.

Газрын төлбөр ногдуулалтаас харахад аймгийн хэмжээнд 2016, 2017 оны байдлаар зам, шугам сүлжээний газрын километр тутмын газар, хадлан, ой, усны сав газраас газрын төлбөр авахаар төлөвлөөгүй байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй уурхайгаас төлбөр ногдуулахаар 2016 онд 24.7 сая төгрөг, 2017 онд 24.3 сая төгрөгийг төлөвлөөгүй байна.

Төлөвлөөгүй уул уурхайн газрын төлбөр ногдуулалт (мянган төгрөгөөр)

№	Сумын нэр	Ашигт малтмалын төрөл	Ашиглалтын талбайн хэмжээ (га)	Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж	Аудитаар газрын төлбөр ногдуулах төлбөрийн хэмжээ	
					2016 он	2017 он
1	Бат-Өлзий	Алт	3446	Гацуурт ХХК	17230.0	17230.0
2	Уянга	Алт	184.1	Өгөөмөр өргөө ХХК	920.5	920.5
		Алт	178.04	Геогулд ХХК	890.2	890.2
		Алт	127.44	Баярсгоулд ХХК	637.2	637.2
		Алт	101.39	Онолтмөнх ХХК	506.95	506.95
		Алт	282.69	Завтайж ХХК	1413.45	1413.45
3	Нарийнтээл	Алт	72.74	Буд-Ундрам ХХК	363.7	-
		Нүүрс	581.74	Баянтээг ХК	2786.7	2786.7
	Дүн				24748.7	24385.0

Аудитад хамрагдсан сумд хөдөө аж ахуйн газрын төлбөр ногдуулалтыг 2016 онд 17.1 сая төгрөгөөр, 2017 онд 15.7 сая төгрөгөөр тооцсон нь аудитаар 2016 онд 7.0 сая төгрөгөөр 2017 онд 8.3 сая төгрөгөөр тус тус дутуу ногдуулсан.

Хот, тосгон бусад суурин газрын төлбөрийн ногдуулалтыг 2016 онд 53.6 сая төгрөгөөр, 2017 онд 52.8 сая төгрөгөөр тооцсон нь аудитаар 2016 онд 20.3 сая төгрөгөөр 2017 онд 58.8 сая төгрөгөөр тус тус дутуу ногдуулсан байна.

Тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж байгаа газрын судалгааг Хархорин сумын Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас авч тооцоолол хийхэд аудитаар 2016, 2017 онд нийт 60.2 сая төгрөг буюу 31.8 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Тусгай хэрэгцээний газрын төлбөр ногдуулалт (мянган төгрөгөөр)

Тусгай хэрэгцээний газар							
№	Сумын нэр	2016 он			2017 он		
		Газрын албанаас төлбөл зохих нийт төлбөр /мян.төг/	Аудитаар төлбөл зохих нийт төлбөр /мян.төг/	Аудитаар дутуу ногдуулсан нийт төлбөр /мян.төг/	Газрын албанаас төлбөл зохих нийт төлбөр /мян.төг/	Аудитаар төлбөл зохих нийт төлбөр /мян.төг/	Аудитаар дутуу ногдуулсан нийт төлбөр /мян.төг/
0	1	15	16	17	15	16	17
1	Бат-Өлзий	2160.0	5472.0	3312.0	2160.0	5472.0	3312.0
2	ЗБУлаан	100.0	520.0	420.0	100.0	520.0	420.0
3	Нарийнтээл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4	Тарагт	720.0	6931.2	6211.2	720.0	7323.2	6603.2
5	Уянга	400.0	3032.0	2632.0	400.0	3128.0	2728.0
6	Хужирт	2052.0	1464.0	-588.0	2052.0	1488.0	-564.0
7	Хархорин	8784.0	13152.0	4368.0	8784.0	11772.0	2988.0
8	Арвайхээр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дүн		14216.0	30571.2	16355.2	14216.0	29703.2	15487.2

Газрын даамлууд төлбөрийн үлдэгдэлтэй аж ахуйн нэгж байгууллагаас газрын төлбөрийг шаардсан гэх боловч өртэй, үлдэгдэлтэй газар эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага, иргэн бүртэй нэг бүрчлэн тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5-д “эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй” үндэслэлээр аймаг, сумын засаг дарга нар 40.1-т 40.2 заалтаар гэрчилгээг хүчингүй болгох, захирамж гаргаж эрх бүхий этгээдэд мэдэгдэх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Аудитаар 2016-2017 онд газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй аж ахуйн нэгж байгууллагуудын газрын төлбөрийг нөхөн төлүүлж аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр нийт 7.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 17-ны 2 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний

зардлыг 162.4 сая төгрөгөөр баталсан ч газар нөхөн сэргээх зардалд тодорхой зардлыг хуваарилан зарцуулаагүй байна.

Аудитаар: Аймгийн Засаг даргад Газрын төлбөрийн орлогын зохих хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зарцуулж байх

Аймгийн ГХБХБГазрын даргад: Хуулийн дагуу ойн сав газар, зам, шугам сүлжээний газрын километр тутмын газар, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй уурхайгаас тус бүрээс газрын төлбөрийг бүрэн ногдуулах, Нэгдмэл сангийн ангиллаар газрын төлбөр ногдуулалтыг сумдын иргэн, аж ахуй нэгжийн газрын улсын бүртгэлтэй тулгалт хийж, нэгж талбар тус бүрээр үндэслэлтэй төлөвлөх, Хууль журмын дагуу газрын төлбөрийн хэмжээг үнэн зөв тооцож байх, Газрын төлбөрийн орлогыг орон нутгийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлэх, хугацаандаа төлөөгүй бол алданги, торгууль тооцож байх, Газар эзэмших эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь төлөхгүй байгаа бол эрхийн гэрчилгээг хүчингүй болгох арга хэмжээ авах, Аймгийн ГХБХБГазрын төлбөр хариуцсан мэргэжилтэн, сумдын газрын даамлуудын ажилд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, дотоод хяналт хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтыг тодорхой болгох, Газрын төлбөрийн орлоготой холбоотой тайлан мэдээний үнэ зөв байдал, төрийн албан хаагчдын ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах зэрэг нийтдээ 9 зөвлөмжийг өгсөн байна.

Аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга, ГХБХБГазар зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

5.4 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим заалтын хэрэгжилт, үр дүн” /ӨВА-2018-01-ГА/-д гүйцэтгэлийн аудитыг хийж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим заалтын 2016-2017 оны хэрэгжилт хангалтгүй байна гэсэн ерөнхий дүгнэлтийг өгсөн.

Аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Бат-Өлзий, Баянгол, Богд, Гучин-Ус, Нарийнтээл, Төгрөг, Уянга, Хужирт, Хархорин зэрэг сумд, аймгийн Татварын хэлтэс, МХГ, ЗДТГ-ын СТСХ, ХЭЗХ зэрэг байгууллагыг хамруулж, 2018 оны 9 дүгээр сарын 10-аас 10 дугаар сарын 31-ний өдрүүдэд гүйцэтгэсэн. /75 хүн өдөр ажилласан/

Аудитаар 4.3 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 4.5 сая төгрөгийн үр өгөөж тооцов.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 72 дугаар тогтоолоор баталсан Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журмын дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэгч зарим иргэд, байгууллага тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй, Худалдаа үйлчилгээний цэгийн гадна, дотно талын дүрст зураггүй, тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл /хуулийн этгээд бол байгууллагын тамга тэмдэг бүхий албан бичиг/-гүй, тохирлын гэрчилгээний хуулбаргүй, тусгай зөвшөөрөл хүсэгчийн иргэний үнэмлэхийн хуулбар байхгүй байсан байна.

Мөн дээрх тогтоолоор баталсан журмын дагуу шаардлага хангасан эсэх талаар цагдаагийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй болон цагдаагийн байгууллагын дүгнэлтээр шаардлага хангаагүй байхад орон тооны бус зөвлөл дэмжсэн дүгнэлт гаргасан байна.

Орон тооны бус ажлын хэсэг болон салбар зөвлөл тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд журмын дагуу хяналт тавиагүй байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийн дүгнэлтгүйгээр зарим цэгүүдэд аймгийн Засаг даргын захирамжаар тусгай зөвшөөрөл олгожээ.

Эрх бүхий нотариатч ажилладаг Арвайхээр, Хархорин сумаас бусад аудитад хамрагдсан сумдаас 2016-2017 онд нотариатын үйлчилгээний хураамж нийт 14.6 сая төгрөг ногдуулж, орон нутгийн төсөвт тайлант онуудад 10.5 сая төгрөгийг, он дамжуулж 0.6 сая төгрөг төсөвт төвлөрүүлж, 3.4 сая төгрөгийг тайлан мэдээнд тусгаагүй, төсөвт оруулаагүй байсанд төлбөрийн акт бичигдсэн байна.

Орон нутгаас олгож буй тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн орлогын биелэлтэд тавих хяналт өмнөх аудитаас харьцангуй сайжирсан ч нотариатын хураамжийн орлогын хураамжид тавих хяналт хангалтгүй байжээ.

Аймгийн Засаг дарга, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо сумын салбар зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтүүдийг аймгийн зөвлөлийн хэлэлцсэн санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргаж байх, журамд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй, зөрчсөн цэгүүдэд тусгай зөвшөөрөл олгохгүй, түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг улсын тэмдэгтийн хураамж бүрэн төлсний дараа олгож байх, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, байршлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативд үндэслэн сумын ИТХ-ын шийдвэрээр тогтоох, тусгай зөвшөөрөл хүссэн худалдаа, үйлчилгээний цэгт тавих босго онооны хэмжээ, хязгаарыг мэргэжлийн байгууллагуудаас баталсан стандарт, шаардлага, дүгнэлт зэргийг харгалзан тогтоох, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тухай хүсэлтийг сумын ИТХ-аас тогтоосон цэгийн тоо, нормативд үндэслэн хүлээн авч, цэгийн тоог нормативаас хэтрүүлэхгүй байх, Улсын тэмдэгтийн хураамжийг нэр төрлөөр үндэслэлтэй төлөвлөж, улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн дагуу тооцож, төсөвт бүрэн төвлөрүүлэх, Нотариатын бүртгэлийн дэвтрийг журмын дагуу хөтөлж, тайлан мэдээг гаргаж хэвших гэсэн нийтдээ 8 зөвлөмжийг өгч, тайланг тушаалаар баталгаажуулан хувийг аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХЭЗХэлтэст болон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлэв.

5.5 Аймгийн Онги-Ус суваг болон Хархорин сумын Хархорин Ус суваг орон нутгийн ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудитыг хийж байгаа бөгөөд 12-р сард тайлагналын шатны ажил дуусахаар хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Тус аймагт “Хөгжлийн банкнаас арилжааны банкаар дамжуулан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, төсөл, хөтөлбөрийн үр дүн”-д аудитыг явуулж, судалгаа мэдээлэл гаргаж, ЯАГ-ын ГАГ-т хүргүүлэв.

“Монгол улсын алт олборлох салбарын өнөөгийн байдал, алтны нөөцийн бүрдүүлэлт”-д хийх аудитын холбогдох судалгааг гаргуулан тайлбар, танилцуулгын хамт ЯАГ-ын ГАГ-т хүргүүлсэн.

Арвайхээр сумын 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн /10-р цэцэрлэг/ барилгын ажлын санхүүжилтийн талаар ирсэн өргөдлийн дагуу аудитыг явуулж, танилцуулга бэлтгэн ЯАГ болон Сизу ХХК-нд хувийг хүргүүлсэн болно.

Зургаадугаар бүлэг.

СУРГАЛТЫН ТАЛААР:

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Л.Ламаачин, ҮАГ-аас зохион байгуулсан “Хөдөлмөрийн чадавхыг дээшлүүлэх” сэдвээр 1 өдрийн сургалтад аудитын менежер Д.Гансүх, аудитор Ч.Гантулга нар оролцсон.

Шинэ ажилтнуудын сургалтад аудитор Ч.Гантулга, ТАБ-ын менежерүүдийн сургалтад Д.Гансүх нар тус тус хамрагдсан.

Сангийн яам болон Азийн хөгжлийн банкны төслөөр “Худалдан авах ажиллагааны аудит” сэдэвт сургалтад ахлах аудитор Б.Чимэдцэрэн, аудитор П.Хорлоосүрэн нар 08-р сарын 20-22-ны өдрүүдэд оролцов.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар 2018-05-30-нд СЗХ-оос зохион байгуулсан хагас өдрийн сургалтад аудитын менежер, ахлах аудиторууд оролцсон байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас “Төрийн болон орон нутгийн өмчийн газрын үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний бэлтгэл хангах нь” сэдэвт сургалтад нягтлан бодогч Р.Цэрэндолгор оролцов.

Байгууллагын 2018 оны дотоод сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажилласан ба 5 сургалт хийж 60 хүн хамрагдан 15 цагийн сургалт хийсэн байна. Үүнд:

Зөрчлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн болон албаны нууцын тухай хууль. Акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам, Аудитын үр өгөөж, Статистик мэдээ, тайлан гаргах журам Гүйцэтгэлийн аудитын журам, Санхүүгийн тайлангийн аудитын журам, Нийцлийн аудитын түр журам зэрэг сургалтуудыг



явуулсан болно.

Төрийн аудитын байгууллагын 2018 оны бүсчилсэн сургалтыг 10-р сарын 18-аас 21-ны хооронд тус аймагт зохион байгуулсан ба бүсчилсэн сургалтад Архангай, Баянхонгор аймгийн Аудитын газрын ажилтнууд оролцов. Тус аймгийн ТАГ-ын ажилтнууд сургалтад бүрэн хамрагдаж, түвшин тогтоох шалгалтад 3 аудитор оролцож, 90.0-100.0 хувийн амжилттай дүн үзүүлэв.

ТАБ-ын 2018-2022 оны сургалт, хөгжлийн стратеги, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу байгууллагын сургалт, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Долоодугаар бүлэг.

БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Тайлангийн хугацаанд тус газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 22 тушаал гаргаж, явсан бичиг 217, ирсэн бичиг 288 бүртгэж, хариутай 43 албан бичгийг хугацаанд шийдвэрлэсэн байна. Мөн ҮАГ-аас дотоод сүлжээгээр танилцуулагдсан мэдээ, мэдээлэл, сургалтад тогтмол оролцон үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр хангаж ажиллаа.

Сар бүрийн үйл ажиллагааны тайлан мэдээ, хүний нөөцийн судалгаа, боловсон хүчний цаг ашиглалт, ирцтэй холбоотой мэдээ зэргийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.

Ажиллагсдын шагналын судалгаа, 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв сонгох төлөвлөгөөний төслийн судалгааг гаргаж, ҮАГ-ын холбогдох газарт тухай бүр хүргүүлэв.

Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, ТАБ-ын 2018 оны сургалтын төлөвлөгөөний төсөл, Төрийн аудитын байгууллагын ёс зүйн дүрмийн төсөл, “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам” болон маягтын төсөл, Мэдээллийн технологийн бодлогын төсөл, Санхүүгийн тайланд аудит хийх журмыг хэрэгжүүлэх заавар, аргачлалын төсөл, Гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн шатанд эрсдэлийг үнэлэх зааврын төсөл, хийгдэх аудитын асуудлын шинжилгээ болон аудитын төлөвлөгөөнд тусгуулах саналыг тухай бүр гаргаж, ҮАГ-ын холбогдох газар, хүмүүст хүргүүлж ажилласан.

Өөрийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгож мэдээллийн самбарт үндсэн ажлын чиг үүрэг хийсэн ажлын товч тайлан, төсвийн зарцуулалтын мэдээ, шалгагдагч байгууллагын талаарх мэдээлэл, санхүүгийн тайлангийн аудит хийх хуваарь зэрэг холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн тавьж ил тод байдлыг хангаж ажиллав.

Байгууллагын вэйб сайт <http://www.audit.ov.gov.mn/>-д тухайн онд хийсэн аудитын тайлан, акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг тавьж байгаа ба ҮАГ-ын нэгдсэн сайт <http://www.audit.mn/>, өөрийн орон нутгийн, <https://www.facebook.com/uvurkhangai.audit> сайтуудад аудитын шалгалтын дүнгийн талаарх товч тайлан, цаг үеийн 29 мэдээллийг тавьж нийт хандалтын тоо 850 хүнд хүрсэн байна.

ҮАГ-ын самбарт тавих байгууллагын түүхчилсэн материал бэлтгэж, ҮАГ-ын Хүний нөөцийн менежерт хүргүүлэв.

Ажилтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар болон цаасаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулж, аудит хийх тухай бүр ашиг сонирхолгүйн зөрчилгүй мэдэгдлийг гаргуулан ажиллаж байна.

Байгууллагад онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулан тагнуулын байгууллагаар хянуулж, зөвлөгөө авч эцэслэн баталсан байна.

Төрийн болон албаны нууц хамгаалах журмын дагуу нууц хамгаалах, тээвэрлэх, тээгчтэй холбоотой 11 бүртгэлийн дэвтрийг хөтөлж, ҮАГ-аас ирүүлсэн нууцтай холбоотой 7 ширхэг тамга тэмдгийг журамд заасны дагуу ашиглаж үйл ажиллагаандаа хэвшил болгоод байна.

Тайланд оны эхэнд 11 ажилтнаас нууцын баталгаа гаргуулан авч, төрийн нууцад хамаарах Зэвсэгт хүний ангиудын санхүүгийн тайланг нууцын ажилтнаар дамжуулан хүлээн

авч холбогдох аудиторуд аудит хийж, материалыг нууцын ажилтан нууцын архивд хадгалан тухай байгууллагад аудитлагдсан тайланг хүргүүлэв.

Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг тооцон ажилласнаар 17 ажлыг төлөвлөснөөс хэрэгжсэн 13, хэрэгжих шатандаа 4, хэрэгжээгүй ажил гараагүй байна.

МУ-н Ерөнхий аудиторын орлогч С.Бүрэнбатаар ахлуулсан шалгалтын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын дагуу төлөвлөгөө гарган ажилласан ба нийтдээ 24 үүрэг даалгавар өгөгдсөнөөс: хэрэгжсэн- 17, хэрэгжих шатандаа-7, хэрэгжээгүй заалт байхгүй, 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагаас зохион байгуулсан шинэлэг ажлаас дурдвал:

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг архивын стандарт шаардлагын хэмжээнд болгох ажил хийгдэж архивд хадгалагдаж буй хадгаламжийн нэгжүүдээс 2003-2018 бүх баримт материалыг стандарт шаардлагад нийцүүлэн засварлаж, үдэж цэгцлэн хадгаламжийн нэгжийг архивд шилжүүлсэн ба аймгийн Аудитын газрын архивын өрөөтэй болсон.

Хүүхдийг дэмжих жил “Хүүхдийн хөгжил хамгаалал-Бидний оролцоо” аяны хүрээнд 7 хоногийн ажлыг зохион байгуулж, Арвайхээр сумын 2-р сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй, тусгай бүлгийн 41 хүүхдүүдэд албан хаагчдаас хандив цуглуулан хичээлийн хэрэгсэл авч өгөв.



Аяны үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, байгууллагын Гэр бүлийн зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг баталсан.

Байгууллагын ажилтнуудын 0-18 нас хүртэлх хүүхдүүдийн судалгаа гаргаж, ажилтнуудын хүүхдүүдийг хүлээн авч, аав, ээжийнхээ ажилтай танилцуулан, аймгийн музей үзүүлж, Арвайхээр хотоо танилцуулан өндөрлөг гаргаж Арвайн хошууны түүхийг ярьж хүүхдүүддээ мэдээлэл өгсөн.

Мөн ажилтнуудаас хүүхдээ эрүүл мэндийн үзлэгт хамруулах эсэх талаар санал асуулга авснаар гар утас болон дэлгэцийн хэрэглээ ихэссэн энэ үед нүдний эмчид үзүүлэх санал гарснаар БОЭТөвийн Нүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 16 хүүхдийг хамруулсан.



Аймгийн төвд нэг цэгийн үйлчилгээний төвд хүүхдийн номын сангийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан ном хандивлах хөдөлгөөнд тус байгууллагын ажилтнууд оролцож, 13 ширхэг ном цуглуулан номын санд хандив өгөв.

Аудиторуудад “Байгууллагын дотоод журам”, “Ёс зүйн дүрэм”-ийг дахин танилцуулж гарын үсгээр баталгаажуулсан.

МУЕА-ын 2018 оны №01 тоотор ирүүлсэн “Ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгаж, ажлын чанар үр дүнг дээшлүүлэх тухай” албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулан ажилласнаар 12 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 11 буюу 91.6 хувийн биелэлттэй байна. Хэрэгжих шатандаа 1 арга хэмжээ байна.

Сахилга, хариуцлага, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор хурууны хээгээр цагийн бүртгэлийг хөтөлж хэвшээд байна.

Чанарын баталгаажуулалтын албанаас тус байгууллагын тогтолцооны болон аудитын түвшний чанарын баталгаажуулалтыг 10-р сарын 01-ээс 04-ны хооронд явуулсан ба өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн аудитын чиглэлээр-3
- Санхүүгийн тайлангийн аудитын чиглэлээр-5
- Нийцлийн аудитын чиглэлээр-4
- Тогтолцооны аудитын чиглэлээр-10 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Хамт олны санаачилгаар “Хамт олны хуримтлалын сан”-г бий болгон өнгөрсөн жилээс эхлэн сар бүр 10-30 мянган төгрөгийг цалингаас суутгуулан, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болсон нь төсвөөс мөнгө зарцуулахгүйгээр албан хаагчдын гачигдал зовлон, зарим нийгмийн асуудлыг шийдвэрлэж байна.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын стресс тайлах, өвлийн улиралд ханиад томуунаас урьдчилан сэргийлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн тайлангийн аудитын ачаалал ихтэй 1-3 дугаар саруудад өдөр бүр халуун чацарганаар үйлчилгээ үзүүлэн 0.2 сая төгрөгийг албан хаагчдын бие эрүүл мэндэд зориулан зарцуулсан.

УИХ-н дэргэдэх байгууллагуудын хооронд зохион байгуулсан шатрын тэмцээнд ахлах аудитор Ц.Отгонням амжилттай оролцсон байна.

2018 онд дарга, Тэргүүлэх аудитор Л.Ламаачин “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, аудитор П.Хорлоосүрэн “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн өмнөх шатны ажил болох СТАУС-д аудит явуулах байгууллагын мэдээлэл, нэмэгдсэн хасагдсан байгууллага, сангуудын мэдээллийг бүрэн шивж оруулав.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын хадгаламжийн нэгжийн бүрдлийг нягтлан баталгаажуулах ажлын хэсгийг Тэргүүлэх аудиторын тушаалаар байгуулан аудитын менежерээр ахлуулан ажиллуулж, архивын нэгжийн бүрдлийг хангуулж, хийсэн ажлын тайлан, илтгэх хуудсыг ҮАГ-т хүргүүлсэн.

Хувийн аудитын компаниудтай СТА хийлгэх гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Наймдугаар бүлэг. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомжийн дагуу явуулан улирал, жилийн тайлан балансаа хугацаанд нь гаргаж, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хууль журамд заасан хугацаанд нь байршуулж ирсэн.

Төсвийн 2018 оны ХБГ-ийн судалгаа
/сая төгрөг/

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар	2018 онд		Үүнээс				Нэмэлт санхүүжилт
	Батлагдсан	Гүйцэтгэл	Цалингийн зардал	Бусад зардал	БҮ-ний бусад зардал	Аудитын зардал	
Дүн	244.6	244.6	191.3	14.7	1.1	0	57.6

Тус газар нь 2018 онд 244.6 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Төрийн сан дахь төсвийн 100100024001 дугаар дансаар гүйлгээ хийн, үйл ажиллагаагаа явуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан. Нэмэлт санхүүжилтийн 100100024401 дугаар дансаар гүйлгээ хийн 9.3 сая төгрөгөөр 4 компьютер, 3 принтер, 1 гар сканер зэрэг хөрөнгийг худалдан авч ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулав.

Байгууллагын авто машинд 4 дугуй авахад 1.6 сая төгрөг, 2 ажилтан хүүхэд төрүүлсний тэтгэмжид 0.7 сая төгрөг, эх үрсийн баяраар ажиллагсдын хүүхдүүдийн бэлэг авахад 0.4 сая төгрөг, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 8.0 сая төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн эрх олгосны дагуу зарцуулсан болно.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай” тогтоол, Сангийн сайдын 2016 оны 126 дугаар “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам” тушаалын дагуу хагас, бүтэн жилийн өмч хөрөнгийн тооллого явуулж, Төрийн өмчийн бодлого

зохицуулалтын газарт 9.3 сая төгрөгийн нийт 8 ширхэг компьютер тоног төхөөрөмж орлогод авах, ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон 4.5 сая төгрөгийн үнэтэй E-office, Web хуудас, программ хангамж /DEA/ зэрэг биет бус хөрөнгийг актлуулахаар санал хүргүүлсэн.

Наймдугаар бүлэг.

Тус газраас 2018 онд үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажилласан.

Санал:

1. Ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх, чадваржуулах. Орон нутгийн аудитын байгууллагын албан хаагчдыг гадаад сургалтад хамруулах.
2. Ажиллагсдын нийгмийн асуудлыг дотоод журамд заасны дагуу шийдвэрлэж байх.
3. Мэдээллийн технологийг аудитын үйл ажиллагаанд үр дүнтэй нэвтрүүлэх.
4. Нууцын ажилтны өрөөтэй болох.
5. Төсөв, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах.

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР...../ Л.ЛАМААЧИН/

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР...../Д.ГАНСҮХ/

2018-12-05